



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 06 сарын 07 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Төмөрпүрэвийн Намнанг томилох тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33.1 дэх заалт, Дээд боловсролын тухай хуулийн 27.1.7, 29.1 дэх заалтууд, "Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн дүрэм"-ийн 4.2 дахь заалт, "Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрэм"-ийн 4.1.8 дахь заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2022 оны 13 тоот тогтоол, 2024 оны 07 тоот тогтоол, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2024 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлөөс зохион байгуулсан сонгон шалгаруулалтын үр дүн, холбогдох шийдвэрийн дагуу Төмөрпүрэвийн Намнанг 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдрөөс Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Ректорын албан тушаалд томилон ажиллуулсугай.

2. Төмөрпүрэвийн Намнантай хөдөлмөрийн гэрээ байгуулахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дарга /М.Батгэрэл/-д зөвшөөрсүгэй.

3. Төмөрпүрэвийн Намнангийн хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу цалин хөлс, холбогдох нэмэгдлийг тооцож олгохыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн ахлах нягтлан бодогч /Б.Алтантуяа/-д зөвшөөрсүгэй.

4. Төмөрпүрэвийн Намнанг томилсон Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн тогтоолыг Боловсрол, шинжлэх ухааны яаманд хүргүүлэхийг Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Н.Ганзориг/-д даалгасугай.

ДАРГА



М.БАТГЭРЭЛ